



МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛЫН ИХ СУРГУУЛИЙН
РЕКТОРЫН ТУШААЛ

2024 оны 05 сарын 15 өдөр

Дугаар А/189

Улаанбаатар хот

Удирдамж батлах тухай

МУБИС-ийн багш, ажилтны бүтээлийг түгээн дэлгэрүүлэх, сурталчлах, тэдний оюуны хөдөлмөр, судалгааны ажлын үнэлэмжийг дээшлүүлэх нэг сэдэвт шилдэг бүтээлийг шалгаруулж, дэмжлэг үзүүлэх зорилгоор МУБИС-ийн Хөгжлийн Бодлого (2014-2024), МУБИС-ийн дүрмийн 4.4.1 дэх заалт, Эрдэм шинжилгээний ажлыг хөгжүүлэх хөтөлбөрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. МУБИС-ийн “Эрдэм шинжилгээний нэг сэдэвт шилдэг бүтээлийг дэмжих хөтөлбөрийн удирдамж”-ыг хавсралтаар баталсугай.

2. Батлагдсан хөтөлбөрийг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг бүрэлдэхүүний болон салбар сургуулийн захирал, тэнхимийн эрхлэгч нарт үүрэг болгосугай.

3. Удирдамжийг хэрэгжүүлэхэд шаардлагатай зардлыг холбогдох журмын дагуу санхүүжүүлэхийг Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга (Д.Тогтохбаяр), Санхүү, хөрөнгө оруулалт, аж ахуйн хэлтсийн дарга (М.Уранжаргал)-д тус тус зөвшөөрсүгэй.

4. Тус удирдамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эрдэм шинжилгээ инновацийн газрын дарга (Б.Хоролдагва)-д даалгасугай.

РЕКТОР



Ж.БАТБААТАР

20241257

МУБИС-ийн ректорын
2024 оны 05 сарын 15 өдрийн А/189
тоот тушаалын хавсралт

МУБИС-ИЙН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ НЭГ СЭДЭВТ ШИЛДЭГ БҮТЭЭЛИЙГ ДЭМЖИХ ХӨТӨЛБӨРИЙН УДИРДАМЖ

МУБИС-ийн багш, ажилтны бүтээлийг түгээн дэлгэрүүлэх, сурталчлах, тэдний оюуны хөдөлмөр, судалгааны ажлын үнэлэмжийг дээшлүүлэх зорилгоор нэг сэдэвт шилдэг бүтээлийг шалгаруулж, дэмжлэг үзүүлнэ.

Нэг. Бүтээлд тавигдах шаардлага

- 1.1 Шалгаруулалтаас 1 жилийн өмнөх хугацааны дотор хэвлэгдсэн байх;
- 1.2 Докторын диссертац, номын бүлэг, орчуулгын болон өмнө нь хэвлэгдэж байсан бүтээлийг шалгаруулалтад оруулахгүй;
- 1.3 Зохиогчид (хамтын бүтээл байж болно) нь МУБИС-ийн үндсэн орон тоонд ажиллаж буй багш, ажилтан байх;
- 1.4 12 хэвлэлийн хуудаснаас доошгүй, ISBN дугаартай хэвлэмэл бүтээл байх;
- 1.5 Аливаа төслийн хүрээнд нийтлэгдээгүй байх.

Хоёр. Бүрдүүлэх баримт бичиг

- 2.1 Бүтээлийг шалгаруулалтад оруулах зохиогчдын хүсэлт
- 2.2 Бүтээлийн хэвлэмэл хувь

Гурав. Шалгаруулалт, дэмжлэг

- 3.1 Зохиогч тухайн оны 09 дүгээр сарын 10-аас өмнө бүтээлээ харгалзах бүрэлдэхүүн болон салбар сургуулийн эрдмийн зөвлөлийн эрдэмтэн нарийн бичгийн даргад хүргүүлнэ. Нэгдүгээр заалтад буй шаардлагыг бүрэн хангаагүй бүтээлийг хүлээн авахгүй.
- 3.2 Бүтээлийг дор дурдсан үзүүлэлтээр үнэлнэ. Үүнд:
 - 3.2.1 Тухайн салбартаа оруулж буй хувь нэмэр, ач холбогдол;
 - 3.2.2 Шинэ мэдлэг бүтээсэн, судалгааны шинэлэг арга зүйгээр бичигдсэн байдал;
 - 3.2.3 Онол, нотолгоонд суурилсан байдал;
 - 3.2.4 Сэдвийн хүрээнд иж бүрэн дүн шинжилгээ хийж, мэдлэгийг системчлэн дүгнэсэн байдал;
 - 3.2.5 Сэдвийн судлагдсан байдал, түүнийг бүтээлд хангалттай тусгасан эсэх
 - 3.2.6 Бүтээлийн бүтэц, агуулга, бичилт;

3.2.7 Хэвлэлийн чанар, дизайн.

- 3.3 Шалгаруулалтад ирсэн бүтээлийг бүрэлдэхүүн болон салбар сургуулийн эрдмийн зөвлөлийн хурлаар хэлэлцэн шалгаруулж, 2 хүртэл бүтээлийг Эрдэм шинжилгээ, инновацын газарт ирүүлнэ.
- 3.4 Ректорын тушаалаар байгуулсан ажлын хэсэг тухайн оны 10 дугаар сарын 01-ний дотор сонгон шалгаруулалтыг явуулна.
- 3.5 Ажлын хэсгийн гишүүд бүтээл бүрийг 3.2-т заасан үзүүлэлтээр дүгнэж, 3 хүртэл бүтээлийг шалгаруулж байр эзлүүлнэ.
- 3.6 Ажлын хэсгийн дүгнэлтийг үндэслэн, шалгарсан бүтээлийн зохиогчдод ректорын тушаалаар судалгааны дэмжлэг олгоно.



Дөрөв. Бусад

- 4.1 Шилдэг бүтээлийн дэмжлэгийг багш нарын баяраар олгоно.
- 4.2 Бүтээл нь ёс зүйн зөрчилгүй байх ба цаашид гарах хариуцлагыг зохиогчид бүрэн хариуцна.